



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/453

Есөнбулаг

Газрын байршил, талбайн хэмжээ  
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан "Газар зохион байгуулалт хийх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2021 оны А/496 дугаар захирамжаар төрийн захиргааны байгууллага (2101)-ын зориулалтаар 8208005818 нэгж талбарт газар эзэмшсэн аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (9016058)-ын эзэмшиж байгаа газрын байршил, талбайн хэмжээг өөрчлөн хавсралтаар баталж, 12 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшсэн аймгийн аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн баталгаажуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3.Газар эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/496 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА




О.АМГАЛАНБААТАР

**ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ГАЗАР ( 9016058 ) - ИЙН  
ЭЗЭМШИХ ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ**

Нэгж талбарын дугаар: 820800...  
Хаяг: Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Баянхайрхан баг



Огноо: 2024-06-19



Хашааны координат:

Дугаар	X	Y	Урт	Цэгүүд
1	5138651.050	288110.556	21.80	1-2
2	5138663.707	288128.306	21.20	2-3
3	5138680.970	288116.000	21.80	3-4
4	5138668.311	288098.246	21.20	4-1

Талбайн хэмжээ: 462.0 квадрат метр

Зургийн масштаб 1:1 000 (1 сантиметрт 10 метр багтана)

